



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/339

Чингис хот

Төсөл сонгон шалгаруулах
дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих” журмын 6.1, 6.2, 6.4, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга:	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Оюунжаргал	Хүнс хөдөө аж ахуйн газрын Жижиг, дунд үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сан, сум хөгжүүлэх сан, зээлийн батлан даалтын сан хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Энх-Амгалан	Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга
	Г.Баярмаа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
	Ч.Мөнх-Эрдэнэ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын тэргүүлэгч
	Д.Энхзаяа	Ажил олгогч эздийн холбооны Хэнтий аймаг дахь салбар холбооны тэргүүн
	Э.Баттөр	Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Хэнтий аймаг дахь салбар хорооны гишүүн
	Б.Цэрэнчимэд	Хэнтий аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дарга

2. Хөнгөлөлттэй зээлийн төслийг журмын дагуу шалгаруулан хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

